

САНХҮҮ ДААТГАЛЫН ХЭЛТЭСИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН АРГА,
ӨРТГИЙН ТООЦООЛОЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ЧУЛУУНЧИМЭГИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
Зорилт 1. “Эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийн санхүүжилтийн өртөгтэй холбогдох заавар, дүрэм, журмыг боловсруулах, даатгуулагчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үр ашгийн тооцоо, төлөвлөлт, хяналт тавих”							
1.	Арга хэмжээ 1.1 Гүйцэтгэлийн санхүүжилтийг зарцуулах хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих” журмын төслийн боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангах.	Батлагдсан журмын огноо, дугаар	50%	100%	Гүйцэтгэлийн санхүүжилтийг зарцуулах хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих” журмын төслийг боловсруулахад өөрийн хариуцсан асуудлын хүрээнд саналыг тусгуулан ажиллаа.	2024.01.01 2024.06.31	30%
2.	Арга хэмжээ 1.2 Эрүүл мэндийн байгууллагуудын төлбөртэй тусламж, үйлчилгээний журмын гүйцэтгэлд үнэлгээ өгч, хэрэгжилтийг хангуулах,	Хэрэгжилтийг хангахтай холбоотой ирүүлсэн албан бичгийн тоогоор	0%	50%	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлж буй төлбөртэй тусламж үйлчилгээтэй холбоотой дүрэм журам, тарифийг судлан үзэж зөрчилтэй дараах захирлын тушаал, журмуудыг хүчингүй болгож шинэчлэн батлуулсан. 1. Эрүүл мэндийн тухай хуулийн 24.3 дах хэсэгт “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж	2024.01.01 2024.12.31	100%

					заасан бөгөөд төрийн өмчийн эрүүл мэндийн зарим байгууллагуудын захирал төлбөртэй тусламж үйлчилгээтэй холбоотой дүрэм журам гаргасныг хүчингүй болгож шинэчлэн батлуулсан Үүнд: Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгийн захирлын 2022 оны А/21 дугаар тушаал, Улсын гуравдугаар төв эмнэлэгийн захирлын 2022 оны А/141 дугаар тушаал, Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын 2022 оны А/12 дугаар тушаал, Халдварт өвчин судлалын үнддэсний төвийн захирлын 2022 оны А/184 дугаар тушаал, 2. Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдаас баталсан төлбөрийн жишиг хэмжээг зөрчиж, төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг тогтоосон шийдвэрийг дахин нягталж хүчингүй болгож шинэчлэн батлуулсан. Үүнд: Эмгэг судлалын үндэсний төвийн захирал 2023.01.31-ний өдрийн А/12 дугаар тушаал (хавсралт 1), Грентологийн үндэсний төвийн захиралын 2022.06.02-ны өдрийн А/35 дугаартай тушаал (хавсралт 3), Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн захиралын 2022.11.29-ний өдрийн А/163 дугаартай тушаал (хавсралт 3).		
3.	Арга хэмжээ 1.3 Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн өртөг, төлбөрийн аргатай холбоотой журмын хэрэгжилтэд хяналт тавьж, зохицуулалт хийж, хэрэгжилтийг хангуулах.	Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн өртөг, төлбөрийн аргатай холбоотой ирүүлсэн албан бичгийн тоогоор	0%	50%	- Арьс өвчин судлалын үндэсний төвөөс 01/32 дугаартай албан бичгээр ирүүлсэн өртгийн тооцооллыг хянаж, ЭМДҮЗ-ын 06, 08 дугаартай тогтоолуудын өөрчлөлтийг хийхтэй холбоотой ЭМСайдын А/400 дугаартай ажлын хэсгийн судалгаанд нэгтгэсэн. - Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 болон Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/49, А/118 хамтарсан тушаалуудаар тус тус батлагдсан “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж үйлчилгээ”-ний жагсаалт, төлбөрийн жишиг хэмжээнд өөрчлөлт оруулахтай холбоотой Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг,	2024.01.01 2024.12.31	100%

					амаржих газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн эмнэлэгүүдэд санал ирүүлэх тухай 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 2/4260 албан бичиг хүргүүлсэн ба нийт 26 байгууллагаас 1265 санал ирсэнийг нэгтгэн, дүн шинжилгээ хийж байна. Үүнд: 535 жагсаалт дээр тарифын санал ирүүлсэн, 730 жагсаалт шинээр нэмэхээр санал ирүүлсэн байна.		
4	Арга хэмжээ 1.4 Эрүүл мэндийн байгууллагуудын цалин хөлсний тогтоол шийдвэртэй холбоотой тооцоолол хийж, нэгжийн удирдлагад танилцуулах	Цалин хөлсний тогтоол шийдвэртэй холбоотой тооцоолол хийсэн нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын тоо	0%	50%	- Гүйцэтгэлээр санхүүждэг 66 байгууллагуудын 2024 оны 01 дүгээр сарын цалингийн мэдээллийг ТАЦНС-ээс татан 2023 оны 241 дүгээр тогтоолтой тулган дундаж үндсэн цалингийн өсөлтийг гаргасан ба хамгийн өндөр дундаж үндсэн цалингийн өсөлттэй байгууллага нь 53.9% буюу 611 мянган төгрөгний өсөлттэй байсан. - 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 128 дугаар тогтоол батлагдсантай холбогдуулан гүйцэтгэлээр санхүүждэг 66 байгууллагуудын 04 дүгээр сарын үндсэн цалинг 128 дугаар тогтоолтой тулган дундаж үндсэн цалингийн өсөлтийг гаргасан ба хамгийн өндөр дундаж үндсэн цалингийн өсөлттэй байгууллага нь 20 % буюу 297 мянган төгрөгний өсөлттэй байна.	2024.01.01 2024.12.31	100%
Зорилт 2. “Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт, зарцуултад төлбөрийн арга, өртгийн тооцоолол, судалгаа, дүн шинжилгээ хийх, нэгдсэн удирдлага аргазүйн зөвлөмжөөр хангах ”							
1	Арга хэмжээ 2.1. ЗГҮАХ 2.1.7.3 Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гаргаж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаар гүйцэтгүүлэн Улсын төсөв (ЭМДС)-өөс	Батлагдсан урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар, Урт хугацааны тусламж, үйлчилгээнд улсын төсөв	10%	50%	Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар турших уг төслийг үр дүнд хүргэх зорилготой Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Ахмад настны урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар турших төлөвлөгөө батлах тухай” А/127, А/333 тушаал батлагдан хамтран хэрэгжүүлж байна.	2024.01.01 2024.12.31	100%

	санхүүжүүлэхтэй холбоотой холбогдох өртгийн тооцоолол хийж Бодлого төлөвлөлтийн газартай хамтран ажиллах.	(ЭМДС)-өөс санхүүжүүлсэн хэмжээ		Эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар боловсруулахад хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байгаа бөгөөд Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэр томъёоны тодорхойлолт, тусламж, үйлчилгээний нэр төрлийн шинэ заалтууд оруулахаар 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 1а/1678 дугаар албан бичгээр саналаа хууль санаачлагчид хүргүүлсэн. Урт хугацааны тусламж, үйлчилгээг дэмжих зорилгоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 08 дугаар тогтоолоор баталсан оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад дагнасан сэргээн засахын тусламж, үйлчилгээний 12 оношийн хамааралтай бүлэг үүсгэсэн. Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд сонгон шалгаруулалтын үндсэн дээр ЭМДЕГ-тай гэрээ байгуулж, иргэн даатгуулагчдад тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн. Даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 08 дугаар тогтоолыг шинэчлэж, 2024.03.29-ны өдөр “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 06 дугаартай тогтоолыг баталсантай холбогдуулан Дагнасан сэргээн засах тусламж, үйлчилгээний амбулаторийн үзлэг 20,800 төгрөг, өдрийн эмчилгээ 223,600-410,800 төгрөг, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ нь 812,600-1,300,000 төгрөгөөр ЭМДС-аас санхүүжиж байна. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар Эрүүл мэндийн даатгалын сангаас Дагнасан сэргээн засахын тусламж, үйлчилгээнд 11.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.		
--	--	--	--	--	--	--

2.	Арга хэмжээ 2.2. ЗГҮАХ 2.1.5.7 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах лавлагаа төвийн чадавхыг нэмэгдүүлж, аймаг, дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна.	10 аймаг	0%	Өртгийн тооцоо хийсэн байна	Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/124 дүгээр тушаалаар батлагдсан "Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх, төлбөртэй тусламж, үйлчилгээний төрөл, орлого, хандив тусламжийг зарцуулах журам" боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж байна. Ажлын хэсгийн хүрээнд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын дагуу өртөг, төлбөрийн аргыг тодорхойлох, дагалдах тооцооллуудыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын гэрээт зөвлөхүүдийн хамт хийсэн ба Эрүүл мэндийн яамны сайт дээр хамтарсан тушаалын төслийг 2024 оны 11 сарын 15-ны өдөр байршуулан олон нийтээс санал авч байна.	2024.01.01 2024.12.31	90%
3.	Арга хэмжээ 2.3. ЗГҮАХ-2.1.13.2 Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний багцыг оновчтой болгож, гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлэхтэй холбоотой өртгийн тооцоолол хийсэн байна.	Гүйцэтгэлийн санхүүжилт нэвтэрсэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв тоо, тусламж үйлчилгээний багцын тоо, өртгийн тооцоолол	0%	50%	ЭМДҮЗ-ын 06, 08 дугаартай тогтоолуудын өөрчлөлтийг хийхтэй холбоотой Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журмыг шинэчлэн боловсруулах Эрүүл мэндийн сайдын ЭМСайдын А/400 дугаартай ажлын хэсэгтэй хамтран байгууллагаас ирүүлсэн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн шинэчлэлтэй холбоотой өртөг тооцоолол, тогтоолын төслүүдийг хянаж, 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 01/725 дугаартай албан бичгээр ЭМДҮЗ-ийн "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 2023 оны 06 дугаар тогтоол, "Жагсаалт, Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 08 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 2024 оны 05 дугаар тогтоол, Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга,	2024.01.01 2024.12.31	100%

					журам шинэчлэн батлах тухай" 2024 оны 06 дугаар тогтоолоор тус тус шинэчлэн баталсан.		
4	Арга хэмжээ 2.4 УИХ-ын 23 дугаар тогтоолын 2.2.1 ЗГҮАХ 2.1.1.5 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 1.3.1 ЭМССТ 1.15 "Элэг бүтэн монгол" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2023 оны арга хэмжээний хэрэгжилт 54.3 хувьд хүрсэн байна.	50%	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/577 дугаар "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний төлөвлөгөөг 2022-2024 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 4 зорилтын хүрээнд 34 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Эрүүл мэндийн сайдын багцын 2024 оны батлагдсан төсөвт "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний зардалд 7.4 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд ЭМС-ын А/345 дугаар тушаалаар Д вирустай иргэдийг эмчилгээнд 4,3 тэрбум төгрөг шилжүүлж, хэрэгжилт 58 %-тай байна.	2024.01.01 2024.12.31	100%
5.	Арга хэмжээ 2.5. МУХТЖҮЧ-2,2,2, ЗГҮАХ-2,1,1, МУХТ 1,3,1 "Элэг бүтэн Монгол" арга хэмжээг хэрэгжүүлж, Д вирустай иргэдийг эмчилгээнд хамруулах ажлын хүрээнд холбогдох өртгийн тооцооллыг хийж, төсвийн төсөлд тусгасан байна.	Арга хэмжээний нэр, холбогдох өртгийн тооцоолол	0%	50%	Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны 2024 оны 04 дүргээр сарын 02-ны хуралдааны 04 дүгээр тогтоолд гепатитын В, D вирус халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх, эмчлэх зорилгоор тодорхой арга хэмжээг авах чиглэлийг Засгийн газарт өгөхөөр хэлэлцэн баталсан ба Монгол Улсын Засгийн газрын 2024 онд "Гепатитын В, D вирусийн халдварын талаар авах арга хэмжээний тухай" тогтоол батлагдаад байна. Үүнтэй холбоотойгоор ЭМС-ын 2024 А/345 дугаар тушаалаар 4.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шилжүүлээд байна. 2025 оны төсвийн төсөлд "Элэг бүтэн Монгол" арга хэмжээ 20 тэрбум төгрөгөөр Сангийн яамруу санал хүргүүлж УИХ 18,1 тэрбум төгрөгөөр хянагдаж 18,1 тэрбум төгрөгөөр өргөн баригдсан.	2024.01.01 2024.12.31	100%

100

6.	Арга хэмжээ 2.6. Эрүүл мэндийн байгууллагуудын сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд үнэлгээ хийж, хагас жил тутамд зөвлөмж, чиглэлийг хүргүүлж, төсвийн сахилга батыг сайжруулахад үнэлгээ хийх.	2 удаа зөвлөмж, чиглэл хүргүүлсэн	0%	50%	Эрүүл мэндийн байгууллагуудад 2024 оны 1а/267, 1а/1721, 1а/2514, 2/3707, 2/3708, 2/3709, 2/3710 дугаарын албан бичгээр 7 удаа, аман байдлаар хөтөлбөр зориулалтын дагуу төсвийг захиран зарцуулж, төсвийн сахилга баттай ажиллах, мөн 2025 оны төсвийн төслийн саналыг үндэслэл тооцоололтой төлөвлөж ирүүлэх талаар зөвлөмж чиглэл өгч ажилласан. Мөн "Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх, төлбөртэй тусламж, үйлчилгээний төрөл, орлого, хандив тусламжийг зарцуулах журам" боловсруулах ажлын хүрээнд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын дагуу өртөг, төлбөрийн аргыг тодорхойлох, дагалдах тооцооллуудыг хийхдээ Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын гэрээт зөвлөхүүдийн хамт ХӨСҮТ, АӨСҮТ-үүд дээр очиж ажилласан.	2024.01.01 2024.12.31	100%
7.	Арга хэмжээ 2.7. Удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулна.	Үйл ажиллагааны тайлан	0	100%	Монгол Улсын эрүүл мэндийн салбарын 2024 оны үйл ажиллагааны хүрээг тодорхойлж, салбарын удирдах ажилтнуудыг нэгдсэн мэдээллээр хангах зорилготой "Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн" 2024 онд 2 удаа зохион байгуулагдсан ба шаардагдах зардлын тооцоо, төсвийг боловсруулж "Төсөв баталж, санхүүжилт олгох тухай" Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/411 дугаар тушаал батлуулсан. Мөн тус зөвлөгөөнүүдэд бүртгэл болон шагнал хариуцсан хэсэгт оролцож ажилласан.	2024.01.01 2024.12.31	100%
8			0%	50%	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах ажлын хүрээнд дараах зөвлөхүүдтэй хамтарч ажиллаж байна. Үүнд: - Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ,		100%

102

	Арга хэмжээ 2.8 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах.	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь			төлбөрийн арга, журмыг шинэчлэн боловсруулах Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/400 дугаар тушаалын хүрээнд Азийн хөгжлийн банкны Санхүүгийн зөвлөхүүдтэй. - Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/124 дүгээр тушаалаар батлагдсан "Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх, төлбөртэй тусламж, үйлчилгээний төрөл, орлого, хандив тусламжийг зарцуулах журам" боловсруулах ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкны "Халдварт бус өвчний хяналт, эмийн аюулгүй байдлыг сайжруулах төслийн Санхүүгийн зөвлөхүүдтэй. - Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/439 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт, журам", "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ", "Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр" төслийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн зөвлөхүүдтэй.	2024.01.01 2024.12.31	
Зорилт 3. "Хууль, тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх"							
1.	Арга хэмжээ 3.1. Харьяалах газар, хэлтсийн даргаас шилжүүлсэн албан бичиг,		0%	50%	Удирдлагаас цохогдон нийт 64 албан бичиг, 35 дотоод меморандум, 1 өргөдөл ирсэн. Үүнээс 63 албан бичиг, 36 дотоод меморандум, 1 өргөдөлийн хариуг хүргүүлсэн. 2 албан бичиг, 1	2024.01.01 2024.12.31	100%

	өргөдлийн хариу хуулийн хугацаанд хүргүүлнэ.	Шийдвэрлэсэн албан бичиг өргөдөл			дотоод меморандум шийдвэрлэх шатандаа байна		
2.	Арга хэмжээ №3.2 2024 оны Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргах	ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд тайлагнасан байна.	0%	100%	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдөр хүргүүлсэн.	2024.01.01 2024.12.31	100%
3.	Арга хэмжээ 3.2. Өөрийн хариуцсан албан тушаалын хүрээнд архив, албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу зохион бүрдүүлж хүлээлгэн өгөх.	Архивд хүлээлгэх өгсөн баримтын тоо	0%	100%	Өөрийн хариуцсан албан тушаалын хүрээнд архив, албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу зохион бүрдүүлж 14 боть баримтыг 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Архивт хүлээлгэн өгсөн.	2024.01.01 2024.12.31	100%
4.	Арга хэмжээ 3.3. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Нэгжийн тайлан, мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргасан байна	0%	50%	- Засгийн газрын болон Улсын Их Хурлын 24 тогтоолын төсөлд хариу хүргүүлсэн. - 2024.02.01, 2024.02.26, 2024.04.01, 2024.04.24 -ний өдрүүдийн сайдын шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэн хугацаанд нь хүргүүлсэн. - Эрүүл мэндийн салбарын 2022-2023 оны хамт/тариф/-ын хэлэлцээрийн хэрэгжилтийг нэгтгэн ТЗУГ-т хүргүүлсэн	2024.01.01 2024.12.31	100%

Хоёр. Нэмэлт ажлын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Дэлхийн эмч нарын өдрийг тэмдэглэх ажлын хэсэгт орж ажиллах, тус арга хэмжээний хүрээнд “Эмч танаараа бахархaya” хүндэтгэлийн арга хэмжээний төсвийг батлуулах	Батлагдсан төсөв	0%	100%	Төрийн нарийн бичгийн даргын баталсан олон улсын эмч нарын өдөрт зориулсан “Эмч танаараа бахархaya-2024” арга хэмжээний бэлтгэл ажлын нарийвчилсан төлөвлөгөө-ний хүрээнд тус арга хэмжээний шаардагдах зардлын тооцоо, төсвийг боловсруулж Төрийн бичгийн даргаар 433.2 сая төгрөг батлуулсан.	2024.01.01 2024.03.31	100%

					UG-arena-д зохион байгуулахад шагнал хариуцсан хэсэгт оролцож ажилласан.		
2.	Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцлийг хянан шалгах түр хорооноос шинжлэн судлах сонсголын хүрээнд нотлох баримтуудыг бэлтгэн хүргүүлэх	Нотлох баримт хүргүүлсэн албан бичгийн тоо	0%	100%	Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцлийг хянан шалгах түр хорооноос шинжлэн судлах сонсголын хүрээнд 2020-2022 онд Улсын хэмжээнд худалдан авсан эм, оношлуур, нэг удаагийн хэрэгслийн нотлох баримтыг архиваас цаасан болон цахим хэлбэрээр бэлтгэн 2024 оны 03 дугаар сарын 2/988 албан бичгээр хариу хүргүүлсэн.	2024.01.01 2024.05.31	100%
3.	Эрүүл мэндийн салбарын 7 хоног арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдах “Эмч нарын 7 дугаар их хурал”, “Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн”, “Багийн эмч нарын зөвлөгөөн”-ийг зохион байгуулахад оролцох.	Батлагдсан төсөв	0%	100%	“Эмч нарын 7 дугаар их хурал”, “Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн”, “Багийн эмч нарын зөвлөгөөн”-д шаардагдах зардлын тооцоо, төсвийг боловсруулж “Төсөв баталж, санхүүжилт олгох тухай” Эрүүл мэндийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/411 дугаар тушаал батлуулсан. Мөн 3 хурал, зөвлөгөөнд бүртгэл болон шагнал хариуцсан хэсэгт оролцож ажилласан.	2024.06.31 2024.12.31	100%

Гурав. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7

1.	Арга хэмжээ 1. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан чиглэлийн сургалтад хамрагдах	Сургалтанд хамрагдсан байна	0%	100%	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан дараах цахим сургалтуудад суусан. Үүнд: - 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх - 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн төрөл, тэтгэмж авах эрх, хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх" - 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр "Төрийн албан хаагчдын сэтгэл ханамж, түүнд нөлөөлж буй хүчин зүйл - 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүйн ба Эрүүл мэнд" - 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүй, гомдол, мэдээлэл, зөрчлийг шийдвэрлэх нь" - 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүй" (Дижитал ёс зүй) - 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүй: Ёс зүй ба бодлого, үйл ажиллагаа - 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр "Төрийн албан хаагчийн цалин хөлс /Орон нутгийн нэмэгдэл/	2024.01.01 2024.12.31	100%
2.	Арга хэмжээ 2. Төрийн худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох АЗ сургалтад хамрагдах	Сургалтанд хамрагдсан байна	0%	0%	Хамрагдаагүй.	2024.01.01 2024.12.31	0%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний
төлбөрийн арга, өртгийн тооцоолол
хариуцсан мэргэжилтэн
(Албан тушаал)

Б.Чулуунчимэг /  /

(Нэр, гарын үсэг)

(Огноо)

127